				51.11 52.13 51.95	Гурван сувагтай хөхлөг зүсэгч хутга /Triple lumen sphincterotome/	S0073	277,000	207,750
					Цэсний ерөнхий сувгийг тэлэгч баллон /Biliary dilation balloon/	S0075	355,000	266,250
					Цэсний сувагт тавих урсгуур /Biliary stent/	S0088	284,000	213,000



					Цөсний сувагтурсгуур тавигч /Stent introducer/	S0089	152,000	114,000
					Цөсний сувагт тавих хамрын урсгуур /Nasal biliary drainage set/	S0327	253,000	189,750
16.5	K87	Нойр булчирхайн сувгийн нарийсал	Нойр булчирхайн сувагт урсгуур тавих /Endoscopic pancreatic stenting/	51.10 51.11 52.13	Чиглүүлэгч /ERCP guidewire/	S0070	250,000	187,500
					Цөсний сувгийн сэтгүүр гуурс /ERCP catheter/	S0072	94,000	70,500
					Гурван сувагтай хөхлөг зүсэгч хутга /Triple lumen sphincterotome/	S0073	277,000	207,750
					Цөсний ерөнхий сувгийг тэлэгч баллон /Biliary dilation balloon/	S0075	355,000	266,250
					Нойр булчирхайн сувгийн урсгуур /Pancreatic stent/	S0091	125,000	93,750
					Нойр булчирхайн сувгийн урсгуур тавигч /Pancreatic stent introducer/	S0092	152,000	114,000
16.6	K74, K76.6, C22, C25	Элэгний хатуурлын үед улаан хоолойн судас өргөсөх эмгэг	Улаан хоолойн өргөссөн судсанд боолт тавих /Endoscopic variceal ligation -EVL/	42.33	Улаан хоолойн хураагуур судасны өргөсөлд тавих боолт-/Endoscopic variceal band ligator/	S0093	240,000	180,000
16.7	K74, K76.6, C22,	Элэгний хатуурлын үед ходоодны судас өргөсөх эмгэг	Ходоодны өргөссөн судсанд цавуу тарих /Glue injection of gastric varices/	42.33	Дурангаар тариа хийх зүү /Endoscopic injector/	S0094	67,000	50,250
					Гистоакрил /N-butyl cyanoacrylate/ цавуу /Histoacryl- N-butyl cyanoacrylate- glue/	S0095	750,000	562,500
16.8	K25-K28 K50-K52	Хоол боловсруулах замын цус алдах эмгэгүүд	Хоол боловсруулах замын цус алдалтыг дурангаар эмчлэх /Endoscopic hemostatis/	42.33 44.43 45.43	Дурангаар тариа хийх зүү /Endoscopic injector/	S0094	67,000	50,250
					Коагуляцийн нэг удаагийн электрод /Disposable patient plate/	S0096	5,000	3,750
					Хий дамжуулагч аппаратны нэг удаагийн гуурс	S0097	450,000	337,500
					Цус тогтоох хэвчээр /Hemostasis clip/	S0098	287,000	215,250
16.9	K31.7 K51.4	Хоол боловсруулах замын хоргүй хавдар	Хоол боловсруулах замын нарийн хөлтэй, өргөн суурьтай ур дурангаар авах /Endoscopic polyp removal/	42.33 45.42 43.41	Дурангаар тариа хийх зүү /Endoscopic injector/	S0094	67,000	50,250
					Цус тогтоох хэвчээр /Hemostasis clip/	S0098	287,000	215,250
					Ур авах уурга /Polypectomy snare/	S0330	81,000	60,750
					Урны суурьт тавигч цагираг /Endoscopic loop/	S0101	110,000	82,500

					Ур татан гаргаагч тор /Polyp extraction endoscopic basket/	S0100	666,000	499,500
16.10	K31.7 K51.4	Хоол боловсруулах замын хоргүй хавдар	Хоол боловсруулах замын өргөн суурьтай ур дурангаар авах /Endoscopic large polyp removal/	42.33 45.42 43.41	Дурангаар тариа хийх зүү /Endoscopic injector/	S0094	67,000	50,250
					Урны суурьт тавигч цагираг /Endoscopic loop/	S0101	110,000	82,500
					Ур авах уурга /Polypectomy snare/	S0330	81,000	60,750
					Ур татан гаргаагч тор /Polyp extraction endoscopic basket/	S0100	666,000	499,500
					Цус тогтоох хавчаар /Hemostasis clip/	S0098	287,000	215,250
16.11	K22	Хоол боловсруулах замын гадны биет	Хоол боловсруулах замаас гадны биет авах /Endoscopic foreign body removal/	42.33 45.42	Гадны биет татагч тор /Foreign body removal basket/	S0102	412,000	309,000
					Шүдтэй хавчаар /Foreign body removal rat tooth forceps/	S0103	707,000	530,250
					Гадны биет авагч гогцоо /Polypectomy snare/	S0104	44,000	33,000
16.12	K22.2	Хоол боловсруулах замын нарийсал	Хоол боловсруулах замын нарийсал тэлэх /Endoscopic balloon dilation/	44.22 42.92 46.85	Улаан хоолой, пилорус, бүдүүн гэдэсний нарийсал тэлэгч баллон /Esophageal, pyloric, colonic dilation balloon/	S0105	1,100,000	825,000
					Чиглүүлэгч /ERCP guidewire/	S0070	250,300	187,725
					Баллон хийлэгч /Inflation device/	S0106	265,000	198,750
16.13	C15, C16 /эрт үеийн/	Хоол боловсруулах замын эрт үеийн хавдар	Хоол боловсруулах замын эрт үеийн хавдар хуулах /Endoscopic mucosal resection and endoscopic submucosal dissection/	42.33 43.41 45.43	Хоол боловсруулах дээд замын эрт үеийн хавдрын үед салст хуулагч багажны иж бүрдэл /Endoscopic mucosal resection -EMR kit/	S0107	2,000,000	1,500,000
					Цус тогтоогч түлэгч хавчаар /Coagrasper/	S0108	377,000	282,750
					Цус тогтоох хавчаар /Hemostasis clip/	S0098	287,000	215,250
					IT2 хумга /IT knife/	S0422	390,000	292,500
					Хумга /Hook knife, needle knife, dual knife/	S0423	684,000	513,000
16.14	K22	Дисфагия	Ходоод, нарийн гэдэсэнд хооллох гуурс тавих /percutaneous endoscopic gastrostomy, Endoscopic nasogastric jejunal	43.11 46.32	Ходоодонд тавих хооллох гуурсны иж бүрдэл /PEG tube set/	S0424	466,000	349,500
					Хамраар тавьдаг нарийн гэдэсний хооллох гуурс /Nasogastric jejunal feeding tube/	S0425	172,000	129,000

			<i>feeding tube placement/</i>		<i>Чиглүүлэгч /ERCP guidewire/</i>	S0070	287,000	215,250
16.15	C15 C16 C18 C19 C24 C25 /хожуу үеийн/	Хоол боловсруулах зам, гуурсан хоолойн хожуу үеийн хавдар	Улаан хоолой, 12 хуруу гэдэс, бүдүүн гэдэс, цөсний зам, гуурсан хоолойн нарийсалд тэлэгч метал стент тавих /Endoscopic insertion of esophageal, pyloric, colonic, biliary, tracheo-bronchial stent/	46.83 31.93 45.89 42.81	<i>Улаан хоолойн метал тэлэгч стент /Esophageal metal stent/</i>	S0426	2,296,000	1,722,000
					<i>12 хуруу гэдэсний метал тэлэгч стент /Duodenal metal stent/</i>	S0427	2,296,000	1,722,000
					<i>Бүдүүн гэдэсний метал тэлэгч стент /Colonic metal stent/</i>	S0451	2,296,000	1,722,000
					<i>Цөсний зам метал тэлэгч стент /Biliary metal stent/</i>	S0428	1,990,000	1,492,500
					<i>Гуурсан хоолойн метал тэлэгч стент /Tracheo-bronchial metal stent/</i>	S0429	2,296,000	1,722,000
16.16	C34	Гуурсан хоолойн ба уушигны хавдар	Гуурсан хоолойн нарийсал, уушигны цагаан мөгөөрсөн хоолой, бронхийн хавдарын нарийсалд метал стент тавих	33.71, 33.91	Метал тэлэгч стент	S0452	2,500,000	1,875,000

#### 17. ЦӨМИЙН ЭМЧИЛГЭЭ

17.1	C22	Элэгний өмөн	Трансартериал 188Re-HDD-Lipiodol элэгний өмөнгийн эмчилгээ	92.20	<i>Судасны интродьюсор</i>	S0430	50,000	37,500
					<i>Үндсэн катетр</i>	S0431	100,000	75,000
					<i>Уян чиглүүлэгч</i>	S0432	140,000	105,000
					<i>Микрокатетр</i>	S0433	1,500,000	1,125,000
					<i>Липиодол</i>	S0434	900,000	675,000
					<i>Нэг удаагийн ариун дэвсгэр</i>	S0435	100,000	75,000

#### 18. ЭРХТЭН ШИЛЖҮҮЛЭН СУУЛГАХ

18.1	K70-77, C22, Z52.6	Элэгний өмөн, хатуурал, цөсний бөглөрөл, элэгний донор	Элэг шилжүүлэн суулгах	50	<i>Судас хавчих үдээс</i>	S0363	30,000	22,500
					<i>Элэгний судас хавчих түгжээтэй үдээс</i>	S0436	45,000	33,750
					<i>Элэг тайрах CUSA аппаратны нэг удаагийн хэрэглээний гуурс</i>	S0364	264,000	198,000
					<i>Элэг тайрах CUSA аппаратны нэг удаагийн түлэгчийн утас</i>	S0365	264,000	198,000
					<i>Элэг тайрах CUSA аппаратны нэг удаагийн хошуувч</i>	S0366	242,000	181,500
					<i>Хэвлийн гуурс вакумтай (3,2mm, 100ml)</i>	S0361	35,000	26,250
					<i>Хэвлийн хальсан наалт</i>	S0367	45,000	33,750
					<i>Рентгений уут (ариун)</i>	S0437	44,000	33,000
					<i>Эхогийн уут (ариун)</i>	S0438	10,000	7,500

Микроскопын уут	S0197	27,000	20,250
Судас оёгч аппарат	S0368	780,000	585,000
Судас оёгч аппаратны цэнэг	S0369	480,000	360,000
Цус тогтоогч	S0032	71,000	53,250
Виоратр (цус эргүүлэх аппаратны) ) нэг удаагийн гуурсний иж бүрдэл	S0370	1,800,000	1,350,000
Виоратр (цус эргүүлэх аппаратны) ) доод хөндийн венийн пампны нэг удаагийн хэрэгсэл	S0371	477,000	357,750
Эрхтэн угаах уусмал	S0439	250,000	187,500
Эдийн цавуу	S0235	350,000	262,500
Цагираг оёгч, тайрагч	S0050	1,000,000	750,000
Шулуун оёгч, тайрагч	S0051	700,000	525,000
Шулуун оёгч, тайрагчийн цэнэг	S0052	300,000	225,000
Судас болон эдийг түлж тайрах дурангийн гар /harmonic, laparoscopic, Aescular/	S0236	1,300,000	975,000
Арьс оёгч	S0273	23,000	17,250
Викрил утас /Vicryl plus/	S0440	21,000	15,750
Хар силк утас /black silk/	S0441	15,000	11,250
Нелон даавуун утас	S0442	67,000	50,250
Полисорб утас /Polysorb/	S0443	41,000	30,750
Софсилк утас /Sofsilk/	S0444	6,000	4,500
Суржипро утас 5.0 17мм 90 см /Surjipro/	S0445	87,000	65,250
Максон утас /Maxon/	S0446	28,000	21,000
ПДС утас 7.0-9.3 мм 70 см /PDS/	S0447	35,000	26,250
Пролин утас 3.0 31 мм 90 см /Prolene/	S0476	27,000	20,250
Пролин утас 3.0 26 мм 90 см /Prolene/	S0477	5,600	4,200
Пролин утас 5.0 /Prolene/	S0478	8,000	6,000
Пролин утас 6.0 9,3 мм 60 см /Prolene/	S0479	14,000	10,500
Пролин утас 6.0 13 мм 75 см /Prolene/	S0480	45,000	33,750
Пролин утас 7.0 /Prolene/	S0481	84,000	63,000
COR-E-TEX 3/8 cc9 mm	S0342	7,000	5,250
Этилон утас	S0448	32,000	24,000
Бүчтэй даавуун уут	S0449	16,000	12,000
Шарх шүршиж угаах баллон	S0450	8,000	6,000

Пледжет	S0453	18,000	13,500
Рентген мэдрэгчтэй зөөлөн гуурс	S0454	18,000	13,500
ERBE аппаратны нэг удаагийн хэрэглээний гуурс	S0455	285,000	213,750
ERBE JET аргон хийний гар	S0456	1,100,000	825,000
Уушигны угийн даралт хэмжих гуурс дамжуулж хийх төвийн венийн 3 салаатай гуурс	S0457	198,000	148,500
Төвийн венийн 3 салаатай гуурс	S0458	156,000	117,000
Цавьны артери венийн даралт хэмжих гуурс	S0459	102,000	76,500
Уушигны угийн даралт хэмжих гуурс	S0460	521,000	390,750
Цусны хийн анализаторын pH, pco2, po2, Hct, Na, K, Ca8 Glucose, Lactate үзэх үзүүлэлт бүхий кит	S0461	1,800,000	1,350,000
Наркозын гүнийг хэмжих хяналтын мониторийн электрод	S0201	48,000	36,000
Мониторын 3 салаатай артерийн даралт хувиргагч	S0462	148,000	111,000
Цус шингэн хурдан юүлэгч аппаратны цус цуглуулах 3 литрийн сав	S0463	320,000	240,000
Цус шингэн хурдан юүлэгч аппаратны холбох гуурс	S0464	209,000	156,750
Цус шингэн хурдан юүлэгч аппаратны өвчтөнд холбох шугам	S0465	22,500	16,875
Цусны бүлэгнэлт тодорхойлох экстем С	S0466	31,000	23,250
Цусны бүлэгнэлт тодорхойлох фибтем С	S0467	19,000	14,250
Цусны бүлэгнэлт тодорхойлох интем С	S0468	18,000	13,500
Цусны бүлэгнэлт тодорхойлох хептем С	S0469	32,000	24,000
Сел сэйвер аппаратны цус ялгах ритр	S0470	2,000,000	1,500,000
Цус шүүж эргүүлэн хийх сав	S0471	1,500,000	1,125,000
Сел сэйвер аппаратны соруулгын гуурс	S0472	500,000	375,000
Хемолок үдээс	S0237	30,000	22,500
ИВ 1000 аппаратны хувиргагч	S0473	526,000	394,500

18.2	I12, E11, N18, N26, N28, Q60-61, Q63.1, Z52.4	Бөөрний архаг дутагдал эцсийн шат, чихрийн шижин, даралт ихсэх өвчин, бөөр хатингарших, бөөрний уйланхай, тах хэлбэрийн бөөр	Бөөр шилжүүлэн суулгах	Шулуун оёгч, тайрагч	S0051	700,000	525,000
				Шулуун оёгч, тайрагчийн цэнэг	S0052	300,000	225,000
				Эдийн цавуу	S0235	350,000	262,500
				Шархны хөндийд тавигдах гуурс	S0474	80,000	60,000
				Шархны халдвар эсэргүүцэгчтэй наалт	S0264	90,000	67,500
				Шээсний катетр	S0265	30,000	22,500
				JJ гуурс /удаан хугацааны/	S0056	350,000	262,500
				Цус тогтоогч	S0032	71,000	53,250
				Пролин утас 5.0 /Prolene/	S0478	8,000	6,000
				Пролин утас 6.0 9,3 мм 60 см /Prolene/	S0479	14,000	10,500
				Пролин утас 6.0 13 мм 75 см /Prolene/	S0480	45,000	33,750
				Пролин утас 7.0 /Prolene/	S0481	84,000	63,000
				Викрил утас /Vicryl plus/	S0440	21,000	15,750
				Артерийн даралт хувиргагч	S0202	150,000	112,500
				Уушигны угийн даралт хэмжих гуурс дамжуулж хийх төвийн венийн 3 салаатай гуурс	S0391	198,000	148,500
				Төвийн венийн 3 салаатай гуурс	S0392	156,000	117,000
				Цавины артери венийн даралт хэмжих гуурс	S0393	102,000	76,500
				Цусны хийн анализаторын pH, pco2, po2, Hct, Na, K, Ca8 Glucose, Lactate үзэх үзүүлэлт бүхий кит	S0475	1,800,000	1,350,000
				Наркозын гүнийг хэмжих хяналтын мониторийн электрод	S0201	60,000	45,000
				Мониторын 3 салаатай артерийн даралт хувиргагч	S0396	148,000	111,000
ИВ 1000 аппаратны хувиргагч	S0473	526,000	394,500				

18.3	T86, M45-99, D50-89, V42	Элэг, бөөр шилжүүлэн суулгах эмчилгээний өмнө болон дараа, Системний холбогч эдийн эмгэгүүд, Цусны хурц болон архаг хавдрууд, Мэдрэлийн зарим эмгэгүүд	Плазмаферез, Тромбоцитоферез, Эритроцитоферез, Лейкоцитоферез, Плазма солих, Эритроцит солих, Орлуулах шингэн	99.79, 99.7	Аферезын багц (Гуурс, шүүлтүүр, төвийн венийн гуурс, антикоагулянт уусмал)	S0482	1,800,000	1,350,000
18.4	C81-C96, T86, D50-89	Ясны чөмөг цусны үүдэл эс шилжүүлэн суулгах эмчилгээ	Эс шүүх эмчилгээ, Эс хөлдөөх эмчилгээ, Эс хадгалах эмчилгээ, Эс шилжүүлэн суулгах эмчилгээ	99.79, 99.7	Байнгын төвийн венийн гуурс, үүдэл эс шүүх, тоолох, боловсруулах, хөлдөөх, хадгалах, буцаан гэсгээж хайлуулах; 1 удаагийн ариун материалууд, HEPA фильтр, шингэн азот, эс хөлдөөх DMSO болон бусад уусмалууд	S0483	38,321,000	28,740,750
18.5	H90.5	Олдмол болон төрөлхийн дүлий	Дунгийн суулгац	20.96	Дунгийн суулгац	S0484	26,000,000	19,500,000

Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн  
2016 оны 03 дугаар сарын 25-ний өдрийн 07  
дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт



**ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГААС ӨНДӨР ӨРТӨГ БҮХИЙ ЗАРИМ  
ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНД ШААРДЛАГАТАЙ ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЭЛ,  
СЭРГЭЭН ЗАСАХ ЗОРИУЛАЛТААР ХИЙГДЭХ ПРОТЕЗ, ОРТОПЕДИЙН  
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ, ХЯНАЛТ ТАВИХ ЖУРАМ**

**Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. Өндөр өртөгтэй зарим тусламж, үйлчилгээнд шаардлагатай эмнэлгийн хэрэгсэл, зарим төрлийн хиймэл цорго, сэргээн засах зориулалтаар хийгдэх протез, ортопедийн зардлын төлбөрийг нь эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх, хяналт тавихтай холбоотой харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2. Эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах өндөр өртөгтэй зарим тусламж, үйлчилгээнд шаардлагатай эмнэлгийн хэрэгсэл, зарим төрлийн хиймэл цорго, сэргээн засах зориулалтаар хийгдэх протез, ортопедийн зардлын төлбөрийг нь санхүүжүүлэхдээ Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоолоор баталсан "Өндөр өртөгтэй зарим тусламж, үйлчилгээнд шаардлагатай эмнэлгийн хэрэгсэл, зарим төрлийн хиймэл цорго, сэргээн засах зориулалтаар хийгдэх протез, ортопед (цаашид "Эмнэлгийн хэрэгсэл, протез" гэх)-ын жагсаалт, даатгалын сангаас олгох зардлын хэмжээ"-г баримтална.

1.3. Эрүүл мэндийн байгууллага нь энэ журмын 1.2-т заасан Эмнэлгийн хэрэгсэл, протезийн худалдан авалтыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулна.

1.4. Эрүүл мэнд, спортын яам, Сангийн яам, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам, Нийгмийн даатгалын байгууллага болон даатгуулагч нь эмнэлгийн хэрэгсэл, протезийн чанар, эрүүл мэндийн даатгалын сангаас болон даатгуулагч өөрөө хариуцан төлөх төлбөрийн хэмжээ зэрэгт холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хяналт тавина.

**Хоёр. Удирдлага зохион байгуулалт**

2.1. Эрүүл мэндийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага нь эмнэлгийн хэрэгсэл, протезийн жагсаалт, үнийг судлах, санал боловсруулах үүрэг бүхий байнгын бус ажиллагаатай ажлын хэсэг ажиллуулж болох бөгөөд ажлын хэсэг нь эрүүл мэндийн, санхүү төсвийн, нийгмийн хамгааллын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага, эрүүл мэндийн даатгалын



асуудал хариуцсан төв байгууллага, эрүүл мэндийн байгууллага, даатгуулагчийн төлөөллөөс бүрдэнэ.



2.2. Ажлын хэсэг нь дараах үүрэг хүлээнэ. Үүнд:

2.2.1. Энэхүү журмаар зохицуулсан эмнэлгийн хэрэгсэл, протезийн жагсаалтыг өвчлөлийн байдал, даатгуулагчийн хэрэгцээ, эрүүл мэндийн даатгалын сангийн чадавхи, орлогын бүрэлдэхүүнтэй холбогдуулан шинэчлэх, өөрчлөлт оруулах санал боловсруулах;

2.2.2. Эмнэлгийн хэрэгсэл, протезийн жишиг үнэ, даатгалын сангаас олгох хэмжээг хэрэглээний үнийн өөрчлөлт, инфляцийн түвшинтэй уялдуулан судалж, шинэчлэх санал боловсруулах, холбогдох газарт уламжлах;

2.2.3. Эрүүл мэндийн даатгалын сангаас төлөх төлбөрийн хэмжээг судалгаа тооцооны үндсэн дээр шинэчлэх, санал боловсруулах;

2.2.4. Эрүүл мэндийн байгууллагын даатгуулагчид үзүүлж буй тусламж, үйлчилгээний гүйцэтгэлд явцын үнэлгээ, тооцоо судалгаа хийж, дүгнэлт гаргах;

2.3. Ажлын хэсэг нь 2.2.1-2.2.4-т заагдсан үйл ажиллагааны талаар дүгнэлт гарган, дараа жилийн төсвийн төсөл, төсөөлөл боловсруулахаас өмнө буюу хоёрдугаар улиралд багтаан Үндэсний зөвлөлөөр хэлэлцүүлэх, эрүүл мэндийн, санхүү төсвийн, нийгмийн хамгааллын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад санал хүргүүлэн хамтран ажиллана.

### **Гурав. Эмнэлгийн хэрэгсэл, протезийн зардлын төлбөр**

3.1. Эрүүл мэндийн даатгалын сангаас тухайн оношоор болон өвчний хүндрэлийн улмаас давтан мэс засалд хэрэглэсэн эмнэлгийн хэрэгсэл, протез, ортопедийн зардлын төлбөрийг Нийгмийн даатгалын байгууллага энэ журмын 1.2-т заасан хэмжээгээр тооцон тухайн тусламж, үйлчилгээ үзүүлсэн эрүүл мэндийн байгууллагад даатгалын сангаас олгож, үлдэх хэсгийг даатгуулагч өөрөө хариуцан төлнө.

3.2. Эмнэлгийн хэрэгсэл, протезийн зардлын төлбөрийг Нийгмийн даатгалын байгууллага энэ журмын 1.2-т заасан хэмжээгээр тооцон тухайн тусламж, үйлчилгээ үзүүлсэн эрүүл мэндийн байгууллагад даатгалын сангаас олгож, үлдэх хэсгийг даатгуулагч өөрөө хариуцан төлнө.

3.3. Энэ журмын 1.2-т заасан эмнэлгийн хэрэгсэл, протезийн үнийн даатгуулагчийн төлөх төлбөрийг “Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах гэрээний үнэ”-ээс эрүүл мэндийн даатгалын сангаас төлөх хэмжээг хассан зөрүүгээр тооцно.

3.4. Дараах тохиолдолд эмнэлгийн хэрэгсэл, протезийн үнийг даатгалын сангаас төлөхгүй. Үүнд:

3.4.1. Эрүүл мэндийн байгууллага нь техникийн үзүүлэлтийн шаардлага хангаагүй, баталгаагүй, чанаргүй эмнэлгийн хэрэгсэл, протез хэрэглэсэн нь эрх бүхий байгууллагын шийдвэрээр нотлогдсон;

3.4.2. Эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн алдааны улмаас өндөр өртөгтэй эмнэлгийн хэрэгсэл, протезийг дахин хэрэглэх шаардлагатай болсон нь эрх бүхий байгууллагын шийдвэрээр нотлогдсон;

3.4.3. Даатгуулагчийн буруутай үйл ажиллагаанаас болж өндөр өртөгтэй эмнэлгийн хэрэгсэл, протезийг дахин хэрэглэсэн тухай Эмчилгээний чанарын хяналтын комиссын шийдвэр гарсан;

3.4.4. Эмнэлгийн хэрэгсэл, протезийг нийлүүлэгч байгууллага нь техникийн үзүүлэлтийн шаардлага хангаагүй, баталгаагүй, чанаргүй эмнэлгийн хэрэгсэл, протезоор хангасан нь эрх бүхий байгууллагын шийдвэрээр нотлогдсон

#### **Дөрөв. Эрүүл мэндийн байгууллагын хүлээх үүрэг**

4.1. Тусламж, үйлчилгээ үзүүлэх эрүүл мэндийн байгууллага нь дараах үүргийг хүлээнэ. Үүнд:

4.1.1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу тендер зарлахдаа тухайн эмнэлгийн хэрэгсэл, протезийн танилцуулга, техникийн үзүүлэлт, чанарын баталгаажилт, үйлдвэрийн бар код, сери дугаар, түүнийг уншуулах боломжит нөхцөлийг хангах талаар тендерийн шалгуур үзүүлэлтэд тусгах бөгөөд сонгон шалгаруулалтад орж эрх авсан нийлүүлэгч компанитай гэрээ байгуулан техникийн үзүүлэлтийн шаардлага хангасан, баталгаатай чанартай эмнэлгийн хэрэгсэл, протезийг худалдан авах, хэрэглэх;

4.1.2. Эрүүл мэндийн байгууллагын тендерийн Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд нийгмийн даатгалын байгууллагын төлөөллийг оролцуулах;

4.1.3. Эрүүл мэндийн байгууллага нь өндөр өртөгтэй тусламж, үйлчилгээнд зайлшгүй шаардлагатай эмнэлгийн хэрэгсэл, протезийг тавихын өмнө, тавьсны дараах баталгаажилт болон тусламж, үйлчилгээний тасралтгүй байдлыг ханган ажиллах,

4.1.4. Эрүүл мэндийн байгууллага нь эмнэлгийн хэрэгсэл, протезийн үнийн төлбөрийн нэхэмжлэлийг “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх, худалдан авах гэрээ”-нд заасан хугацаанд нийгмийн даатгалын байгууллагад ирүүлэх;

4.1.5. Эрүүл мэндийн байгууллага нь эмнэлгийн хэрэгсэл, протезийн үнийг нийгмийн даатгалын байгууллагаас нэхэмжлэхдээ дараах баримт бичгийг бүрдүүлэх:

- а. Тухайн мэс засал хийлгэсэн даатгуулагчийн өвчний түүх;
- б. Энэ журмын 5.1.2-д заасан тэмдэглэл хүснэгтийн дагуу гаргасан мэдээлэл;
- в. Эмнэлгийн хэрэгсэл, протезийн үнийн даатгуулагчийн өөрөө хариуцан төлсөн төлбөрийн баримтын нэг хувь;

4.1.6. Тухайн мэс засалд хэрэглэсэн эмнэлгийн хэрэгсэл, протезийн үйлдвэрийн бар код, сери дугаарыг энэ журмын 5.1.2-д заасан тэмдэглэл хүснэгтэд бичих буюу наасан байх;

4.1.7. Эрүүл мэндийн байгууллага нь тендэрт шалгарсан нийлүүлэгч компаний нэр, эмнэлгийн хэрэгсэл, протезийн танилцуулга, техникийн үзүүлэлт, чанарын баталгаажилт, түүний эрүүл мэндийн даатгалын сангаас болон даатгуулагчийн хариуцан төлөх төлбөрийн хэмжээ зэргийг ил тод, даатгуулагчдад ойлгомжтой хэлбэрээр байршуулан даатгуулагчдыг мэдээллээр хангах;

4.1.8. Энэхүү журмаар зохицуулсан заалтаас бусад нэмэлт төлбөр даатгуулагчаас авахыг хориглох.

4.1.9. Эрүүл мэндийн байгууллага нь энэ журмын 1.2-т заасан хэмжээнээс бага үнээр эмнэлгийн хэрэгсэл, протезийг нийлүүлэгч байгууллагаас авсан бол энэ журмын 1.2-т заасан эрүүл мэндийн даатгалын сангаас хөнгөлөх хэмжээгээр тооцож, нэхэмжилнэ.

4.1.10. Эрүүл мэндийн байгууллага нь уг тусламж, үйлчилгээний талаарх санал, хүсэлтээ холбогдох газарт уламжлах, шийдвэрлүүлэх;

### **Тав. Нийгмийн даатгалын байгууллагын хүлээх үүрэг**

5.1. Нийгмийн даатгалын байгууллага дараах үүрэг хүлээнэ. Үүнд:

5.1.1 "Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх, худалдан авах гэрээ" байгуулсан эрүүл мэндийн байгууллагын даатгуулагчийн мэс заслын тусламж, үйлчилгээнд хэрэглэсэн эмнэлгийн хэрэгсэл, протезийн үнийн төлбөрийн нэхэмжлэл, жагсаалтын 80 хувийг урьдчилан шилжүүлж, энэ журмын 4.1.5-д заасан баримт бичгийг хянан шалгасны үндсэн дээр гүйцэтгэлээр тооцон баталсан төсвийн хүрээнд санхүүжүүлэх;

5.1.2. "Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих өндөр өртөгтэй зарим тусламж, үйлчилгээнд шаардлагатай эмнэлгийн хэрэгсэл, сэргээн

засах зориулалтаар хийгдэх протезийн тухай тэмдэглэл хүснэгт"-ийн загварыг батлах;

5.1.3. Эмнэлгийн хэрэгсэл, протезийн үнийн төлбөрийн санхүүжилтийг энэ журам болон дараах эрх зүйн акт, баримт бичгийг үндэслэн олгох; Үүнд:

а. Энэ журмын 1.2-т заасан эрүүл мэндийн даатгалын сангаас олгох хэмжээ;

б. Эрүүл мэндийн байгууллагаас ирүүлсэн энэ журмын 4.1.5-д заасан баримт бичиг;

в. Шилэн дансны тухай хуулийн дагуу худалдан авсан эмнэлгийн хэрэгсэл, протезийн талаарх эрүүл мэндийн байгууллагын гаргасан мэдээлэл.

5.1.4. Эмнэлгийн хэрэгсэл, протезийн үйлдвэрийн бар код, сери дугаар, мэдээллийн сан, хяналтын програм хангамж, даатгуулагчийн мэдээлэл, эрүүл мэндийн байгууллагын анхан шатны баримт бичиг зэрэгт эмнэлгийн хэрэгсэл, протезийн тендерийн гэрээний үнэ, даатгуулагчид үзүүлж байгаа үнийн хөнгөлөлт, хамтын төлбөрийн асуудалд хяналт тавьж, зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх, илэрсэн зөрчлийг арилгах, даатгуулагчийн гомдлыг барагдуулж хохиролгүй болгох зэрэг хууль тогтоомжийн дагуу арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

5.1.5. Энэ журмын 4.1.1-д заасан худалдан авалтын талаарх мэдээлэл (тендер зарлах үйл явц, үнэлгээний хорооны шийдвэр, тендерт шалгарсан байгууллагын нэр, танилцуулга, уг байгууллагаас нийлүүлэх эмнэлгийн хэрэгсэл, протезийн нэр, үнийн мэдээлэл)-ийг Шилэн дансны хуулийн дагуу тухайн эрүүл мэндийн байгууллагын цахим хуудаснаас авах;

5.1.6. Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих өндөр өртөгтэй зарим тусламж, үйлчилгээнд шаардлагатай эмнэлгийн хэрэгсэл, сэргээн засах зориулалтаар хийгдэх протезийн төлбөрийг халамжийн сангаас даатгуулагчид давхардуулан олгохгүй байх талаар Нийгмийн халамж, үйлчилгээний газартай хамтран ажиллах;

### **Зургаа. Хариуцлага**

6.1. Энэ журам болон "Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх, худалдан авах гэрээ"-гээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, даатгуулагчаас илүү төлбөр авсан, даатгуулагчид чанар, техникийн үзүүлэлтийн шаардлага хангаагүй эмнэлгийн хэрэгсэл, протез нийлүүлсэн, хэрэглэсэн, хуурамч баримт бичиг бүрдүүлж эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжилт авсан нь нотлогдсон тохиолдолд тухайн албан тушаалтан, байгууллага, иргэнд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.